

**ХИЛИЙН УС БОЛОН ОЛОН УЛСЫН НУУРУУДЫГ
ХАМГААЛАХ, АШИГЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ**

1992 оны 03 дугаар сарын 17

Хелсинк хот

Оршил хэсэг

Энэхүү конвенцийн талууд

Хилийн ус, олон улсын нуурыг хамгаалах, ашиглах нь чухал зорилт бөгөөд түүнийг үр ашигтай хэрэгжүүлэх нь нягт хамтын ажиллагааны замаар хийгдэнэ гэдгийг **ухамсарлаж;**

Хилийн ус болон олон улсын нууруудын өөрчлөлт нь богино хугацаанд болон алс хэдээ Европын Эдийн засгийн Комиссын гишүүн орнуудын хүрээлэн буй орчин, эдийн засаг, сайн сайханд сөрөг үр дагаврыг бий болгох аюултай байгаад санаа зовниж байгаагаа **илэрхийлэн;**

Усан орчны аюултай хог хаягдлыг зайлуулах, хязгаарлах, багасгах, исэлдэл болон эвтофикацийг багасгах, эх газарт байрлах эх үүсвэрээс ялангуяа далайн захын нуурын бохирдлыг багасгах талаар үндэсний болон олон улсын арга хэмжээг сайжруулахыг тэмдэглэж;

ЕЭЗ-ийн гишүүн орнуудын Засгийн газруудын хилийн усны бохирдлыг зайлуулах, хязгаарлах, бууруулах усны нөөцийн тогтвортой удирдлага, хүрээлэн буй орчин, тэдгээрийг хамгаалах талаар хоёр талын болон олон талын авч буй арга хэмжээнүүд, идэвхи санаачлагыг дэмжиж;

Хүний хүрээлэн буй орчны асуудлаархи Стокгольмын бага хурлын тунхаглал, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны зөвлөлгөөний Төгсгөлийн акт, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны Мадридын болон Венийн уулзалтын төгсгөлийн баримт бичиг, ЕЭЗК-ийн гишүүн орнуудын 2000 он болон цааши хугацаанд хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах бүс нутгийн стратегийн суурь нөхцөл, зарчмууд дээр тулгуурлан;

НҮБ-ын ЕЭЗК нь хилийн усны бохирдлыг зайлуулах, хязгаарлах, багасгах, тэдгээрийн тогтвортой ашиглалтын талаар ЕЭЗК-ийн усны нөөц, түүний дотор хилийн усны бохирдлоос урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх бодлогын тунхаг бичигт тулгуурлан, ЕЭЗК-ийн усны нөөцийг үр ашигтай ашиглах бодлогын тунхаглал, ЕЭЗК-ийн хилийн усны салбарт хамтран ажиллах зарчим, ЕЭЗК-ийн газар доорхи усыг үр ашигтай ашиглах харт, хилийн дотоодын усны аваарын бохирдлын үед авах арга хэмжээний хууль зэрэгт ЕЭЗК-ийн үүрэг ролийг ухамсарлаж;

ЕЭЗК-ийн 42, 44 дүгээр чуулганы шийдвэрүүд, хүрээлэн буй орчны талаар оролцогч орнуудын төлөөлөгчдийн зөвлөлгөөний үр дүн, (1989 оны 11 сарын 03, 10 сарын 16-ны Болгарын Софи хот), шийдвэрүүдийг иш үндэс болгон;

Гишүүн орнуудын хилийн усыг хамгаалах, ашиглах талаархи хамтын ажиллагаа нь юуны өмнө нэг усаар хиллэж байгаа эргийн орнуудын хооронд хэлэлцээр байгуулах замаар ялангуяа ийм хэлэлцээр тохиролцоонд хараахан хүрээгүй гэдгийг тэмдэглэж;

Дараахи тохиролцоонд хүрэв.

**ЗҮЙЛ 1
ТОДОРХОЙЛОЛТ**

Энэхүү конвенцид хэрэглэсэн нэр томъёог дараахи байдлаар ойлгоно.

1."хилийн ус" гэж хоёр болон түүнээс олон улсын хилийг огтлон тэмдэглэгдэж байгаа аливаа гадаргын болон газрын доорхи мөн ийм хил дээр оршиж байгаа далайд шууд цутгаж байгаа хилийн ус, бага усны шугам тэдгээрийн эрэг дээр орших урсгалуудын хоорондох голын адаг хэсгийг огтолсон шулуун шугамаар холбосон хилийн усны хязгаарыг;

2."хилийн нөлөөлөл" гэж аль нэг талуудын бүрэн эзэмшилд байгаа нутаг дэвсгэр дээрх хүний үйл ажиллагаа, хэсэгчилсэн буюу бүрэн байдлаар орших бодит эх үүсвэрийн нөлөөллөөр хилийн усны өөрчлөлтийн үр дүнд талуудын бүрэн эзэмшилд байгаа хүрээлэн буй орчинд бий болох томоохон хортой үр дагаврыг. Хүрээлэн буй орчны ийм үр дагаварт хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, ургамал, хөрс, агаар, ус, цаг уур, ландшафт, түүхийн дурсгалт зүйлс, бусад материаллаг объектууд, мөн эдгээр хүчин зүйлийн харилцан үйлчлэл, мөн эдгээрт соёлын өв, эдгээр хүчин зүйлийн өөрчлөлтөд бий болсон нийгэм-эдийн засгийн нөхцлүүдийг ойлгоно;

3."Талууд" гэж энэхүү конвенцид өөрөөр заагаагүй бол энэхүү конвенцийн харилцан тохирогч талыг;

4."эргийн талууд" гэж нэг хилийн усаар хиллэж байгаа талуудыг;

5."хамтарсан байгууллага" гэж аливаа хоёр талын болон олон талын комисс, эргийн талуудын хооронд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий холбогдох зохион байгуулалтын бүтцийг;

6."аюултай бодис" гэж аюултай, канцероген, мутаген, тератоген, биохуримтлалын тогтвортой бодисыг;

7."хамгийн сайн технологи" (энэхүү конвенцийн 1 дүгээр хавсралтад заасан тодорхойлолтыг);

БҮЛЭГ I

БҮХ ТАЛУУДАД ХАМААРАХ ДҮРЭМ

Зүйл 2

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Талууд аливаа хилийн нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах талаар холбигдох бүх арга хэмжээг авна.
- Талууд дараахи зохих арга хэмжээнүүдийг авна.
 - Хилийн нөлөөлөл үзүүлж байгаа болон үзүүлж болох усны бохирдлыг зайлуулах, хязгаарлах, багасгах;
 - Экологийн үндэслэлтэй, усны нөөцийн үр ашигтай удирдлагыг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгод нийцсэн хилийн усны ашиглалтыг бий болгох;
 - Хилийн усны ухаалаг, шудрага хэрэгцээг хангахын тулд тэдгээрийг хилийн усны шинж чанар, хилийн нөлөөлөл үзүүлж байгаа болон үзүүлж болох үйл ажиллагааг онцгой анхаарч үйл ажиллагааг явуулах;
 - Хилийн усыг хадгалах зорилгоор шаардлагатай нөхцөлд экосистемийн нөхөн сэргээлт хийх;

3.Усны бохирдлыг зайлуулах, хязгаарлах, багасгах зорилгоор бололцоотой бүх арга хэмжээг бохирдлын эх үүсвэрт авч хэрэгжүүлнэ;

4.Эдгээр арга хэмжээ нь шууд болон шууд бусаар хүрээлэн буй орчны бусад бүрэлдэхүүнд бохирдлыг зөөвөрлөхөөргүй байна;

5.Энэхүү зүйлийн 1, 2 дугаарт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ Талууд дараахи зарчмуудыг удирдлага болгоно;

а)аюултай бодис зөөгдөх замаар боломжит хилийн нөлөөллийг зайлуулах зорилгоор хийгдэж байгаа урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь судалгаагаар тогтоогоогүй гэж хойшлуулах, эдгээр бодисуудын учир, шалтгааны холбоо бүрэн хэмжээгээр шинжлэх ухааны судалгаа тогтоогоогүй гэх шалтгаанаар нэг талаас нөгөө талаас боломжит хилийн нөлөөллөөс хойшлуулахгүй байх зарчим;

б)бохирдуулагч-төлөгч гэсэн зарчмаар бохирдлоос урьдчилан сэргийлэх, зайлуулах, багасгах бүх үйл ажиллагааны зардлыг бохирдуулагч төлнө;

с) усны нөөцийн менежмент нь өнөө үеийн хэрэгцээг хохирол багатай байхаар хийгдэхээс гадна ирээдүй үеийн усны хэрэгцээг бүрэн хангасан байхаар хийгдэнэ;

6.Эргийн талууд нь тэгш эрх, харилцан бие биеэ хүндэтгэсэн байдалд хамтын ажиллагаатай байхаас гадна далайн орчинг хамруулаад усны нөлөөлөлд байгаа хүрээлэн буй орчин, хилийн усны хүрээлэн буй орчинг хамгаалах зорилгоор холбогдох ус хуримталын талбай, тэдгээрийн хилийн усны нөлөөллийг зайлуулах, хязгаарлах,багасгах иж бүрэн зөвшилцсөн бодлого, стратеги, тактик боловсруулах зорилт бүхий хоёр талын болон олон талын гэрээр хэлэлцээр байгуулан ажиллана;

7.Энэхүү конвенцийг ашигласнаар экологийн нөхцлийг бууруулах, хилийн усны нөлөөллийг нэмэгдүүлж үл болно;

8.Энэхүү конвенцийн дүрэм нь Талууд бие дааж болон хамтарсан хэлбэрээр тус конвенцид зааснаас илүү хатуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхийг үл хязгаарлана;

Зүйл 3

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХЯЗГААРЛАХ , БАГАСГАХ

1.Хилийн нөлөөллийг урьдчилан сэргийлэх, хязгаарлах, багасгах зорилгоор Талууд холбогдох эрх зүй, засаг захиргаа, эдийн засаг, санхүү, техникийн арга хэмжээг боловсруулж, батлаж, хэрэгжүүлэх бөгөөд аль болох тэдгээрийн үйл ажиллагааг хамтатгах арга хэмжээ авахаас гадна:

а)бохирдуулагч эх үүсвэрийг зайлуулах, хязгаарлах, багасгахын тулд хаягдал багатай, хаягдалгүй технологийг хэрэглэх замаар;

б)хилийн усыг цэгэн бохирдлын эх үүсвэрээс хамгаалахын тулд эрх бүхий байгууллагууд хаягдал усыг хаях урьдчилсан зөвшөөрөл өгөх замаар мөн зөвшөөрөгдсөн хаягдалд хяналт-шалгалт хийх замаар;

с)хаягдал усны зөвшөөрөл олгохдоо аюултай хаягдал бодисын хамгийн шилмэл технологи дээр тулгуурласан зөвшөөрөх хэмжээний нормыг тогтоох;

д)зарим тохиолдолд зөвшөөрөгдсөн хаягдалд илүү хатуу шаардлага тавих, хэрэв шаардлага гарвал ус авах төхөөрөмж болон экосистемийн шаардлагатай чанарыг хангах;

е)нийтийн аж ахуйн хаягдал усны хувьд хамгийн багаар биологийн цэвэрлэгээ, түүнтэй адилтгах технологийг ашиглах, гэхдээ шаардлагатай бол үүнийг үе шаттай хэрэгжүүлэх;

ф)үйлдвэрийн болон нийтийн аж ахуйн эх үүсвэрээс гарах биологийн бодисын хэмжээг багасгах зорилгоор байгаа хамгийн сайн технологийг ашиглах мөн холбогдох арга хэмжээг авах;

г)диффузийн эх үүсвэрээс ялангуяа бохирдлын эх үүсвэр нь хөдөө аж ахуй байгаа тохиолдолд биологийн болон аюултай бодисыг багасгахын тулд экологийн практикт хамгийн сайн холбогдох арга хэмжээнүүдийг боловсруулах, ашиглах(энэхүү конвенцийн II хавсралтад экологийн хувьд хамгийн сайн боловсруулалтад зориулсан хөтлөгч зарчмуудыг хавсаргасан.);

- h)хүрээлэн буй орчны тогтвортой нөлөөлөл бусад үнэлгээний аргуудыг хэрэглэх;
- i)усны нөөцийн тогтвортой менежментийг дэмжих, экосистемийн хандлагыг хэрэглэх;
- j)онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах;
- k)газар доорхи усыг бохирдлоос сэргийлэхийн тулд нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;
- l)аваарийн бохирдлын аюулг аль болох багасгах;

2. Энэхүү зорилгоор Тал тус бүр цэгэн эх үүсвэрээс гадаргын усанд хаягдаж байгаа бохирдлын агуулгын зөвшөөрөгдөх хэмжээг байгаа хамгийн сайн технологи дээр тогтооно; Аюултай бодисын эх үүсвэр бүрээр тодорхой салбар тус бүрээр мөн үйлдвэрийн сектор бүрээр гаргана.Энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт заагдсан цэгэн диффузийн эх үүсвэрээс гарч байгаа аюултай бодисыг зайлуулах, хязгаарлах, багасгах, холбогдох арга хэмжээг авах бөгөөд мөн тэрчлэн үйлдвэрлэл болон ийм бодисыг ашиглах хэсэгчлэн болон бүрэн хориглолтыг хийнэ. Мөн ийм салбарын жагсаалт, үйлдвэрийн секторын жагсаалтыг гаргаж анхааралдаа авахаас гадна энэхүү конвенцид хамаарагдах олон улсын конвенци, дүрэмд тусгагдсан аюултай бодисын жагсаалтыг гаргах хэрэгтэй;

3.Тал тус бүр хилийн усны нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах зорилгоор боломжтой газруудад усны чанарын зорилтот үзүүлэлтүүд мөн усны чанарын шалгуурыг тодорхойлох хэрэгтэй. Ийм үзүүлэлтүүд, шалгууруудыг боловсруулах үндсэн зарчмуудыг энэхүү Конвенцийн 3 дугаар хавсралтад үзүүлсэн болно.

Шаардлагатай үед талууд энэхүү хавсралтыг шинэчлэхэд чиглэгдсэн урьдчилсан арга хэмжээг авна.

Зүйл 4 ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Талууд хилийн усны байдлын хяналт-шалгалтын хөтөлбөрийг боловсруулна.

Зүйл 5 СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ

Талууд хилийн нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах салбарт үр ашигтай арга хэрэглэхийн тулд судалгааны боловсруулалтыг явуулна. Энэхүү зорилгоор Талууд холбогдох олон улсын хурал, зөвлөлгөөний шинжлэх-ухаан-судалгааны үйл ажилагааг харгалзан хоёр талын болон олон талын үндсэн дээр хэрэгжүүлэхийг эрэлхийлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд тодорхой шинжлэх-ухааны судалгааны хөтөлбөрийг дараахи чиглэлээр идэвхижүүлнэ. Тухайлвал:

- а)аюултай бодис, бохирдуулагчийн хор, хортой нөлөөллийн үнэлгээний аргачлалыг боловсруулах;
- б)бохирдуулагч болон холбогдох процессын хүрээлэн буй орчинд илрэх, тархах, нөлөөллийн талаархи мэдлэгийн төвшинг дээшлүүлэх;
- с)экологийн хувьд үндэслэлтэй технологи, үйлдвэрлэлийн арга, хэрэглээний бүтцийг боловсруулах, хэрэглэх;
- д)хилийн нөлөөлөл үзүүлж болох үйлдвэрлэл, хэрэглээ түүнийг орлуулах бодисын хэрэглээ зэргийг үе шаттай зогсоох;
- е)аюултай бодисыг зайлуулах талаар экологийн үндэслэлтэй аргыг боловсруулах;
- ф)хилийн усны байдлыг сайжруулах талаар тусгай арга боловсруулах;

g)экологийн үндэслэлтэй усны аж ахуйн объектуудын барилга байгууламжийн аргууд, усны горимын зохицуулалтын аргыг боловсруулах;

h)хилийн нөлөөллийн үр дүнд бий болсон биет болон санхүүгийн үнэлгээг хийх;

Зүйл 6 МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО

Талууд аль болох богино хугацаанд энэхүү Конвенцийн дүрэмд хамрагдсан асуудлаар өргөн мэдээлэл солилцох ажиллагааг хангана.

Зүйл 7 ХАРИУЦЛАГА

Талууд хариуцлагын норм-шалгуур, журам боловсруулах талаар холбогдох олон улсын идэвхитэй дэмжлэг тусалцаа авна.

Зүйл 8 МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ

Энэхүү конвенцийн журам нь Талуудын үйлдвэрлэлийн болон худалдааны нууцад хамааралтай ашиглаж буй мэдээллийн үндэсний эрх зүйн систем түүний дотор оюуны өмч, үндэсний аюулгүй байдлын сонирхлыг үл хөндөнө.

ХЭСЭГ II ЭРГИЙН ТАЛУУДАД ХАМААРАХ ДҮРЭМ

Зүйл 9 ХОЁР ТАЛЫН БОЛОН ОЛОН ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1.Эргийн талууд нь одоо мөрдөж байгаа гэрээ хэлэлцээрүүдэд байхгүй буюу өөрчлөлт оруулах шаардлагатай болон энэхүү хэлэлцээрийн үндсэн зарчмуудтай зөрчилдөж байгаа бол түүнийг арилгах, хилийн нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах зорилгоор харилцаа үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох зорилгоор хоёр талын болон олон талын гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулж болно. Эргийн талууд нь ус хуримтлуулах талбайн хил хязгаар, түүний хэсгийн хил заагийг маш тодорхой заагласан байна. Мөн тэрчлэн гэрээ хэлэлцээрүүд нь энэхүү Конвенцид тусгагдсан холбогдох асуудлуудыг хамарсан байхаас гадна эргийн Талууд хамтран ажиллах шаардлагатай гэсэн асуудлуудыг тусгасан байна.

2.Энэхүү бүлгийн 1 дүгээр зүйлд заасан гэрээ, хэлэлцээрүүд нь хамтарсан байгууллага байгуулах асуудлыг тусгасан байна. Энэхүү хамтарсан байгууллагын зорилго нь одоо байгаа гэрээ, хэлэлцээрүүдэд хохирол учруулахгүй байхаас гадна мөн:

а)хилийн нөлөөлөл үзүүлж болох бохирдлын эх үүсвэрийг тодорхойлох зорилгоор мэдээлэл цуглуулах, нэгтгэх, үнэлэх;

б)усны чанарын болон тоон үзүүлэлтээр хяналт-шалгалт хийх хамтарсан хөтөлбөр боловсруулах;

с)энэхүү зүйлийн 2 дугаар хэсэгт заасан бохирдлын эх үүсвэрийн талаар мэдээлэл солилцох реестр хөтлөх;

д)хаягдал усны зөвшөөрөх хэмжээг боловсруулах, бохирдолтой тэмцэх хөтөлбөрийн үр дүнг үнэлэх;

е)Энэхүү Конвенцийн 3 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт заасан журмын дагуу усны чанарын зорилтот нэгдсэн үзүүлэлт, шаардлагатай тохиолдолд усны байгаа чанарыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх санал боловсруулах;

f)цэгэн болон (жишээлвэл нийтийн аж ахуйн болон үйлдвэрийн хаягдал) диффузын бохирдлын эх үүсвэрийн (ялангуяа хөдөө аж ахуйн) ачааллийг бууруулах талаар нэгдсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах;

g)мэдээлэл, дохиоллын журмыг тогтоох;

i)форум хурлын хэлбэрээр одоо байгаа болон төлөвлөж буй ус ашиглалтын талаар, хилийн нөлөөлөл үзүүлж болохуйц холбогдох төхөөрөмжийн талаар мэдээлэл солилцох;

j)олон улсын холбогдох хэм хэмжээний үндсэн дээр хилийн усны хүрээлэн буй орчинд нөлөөлөх үнэлгээ хийхэд оролцох;

3.Далайн захын орнууд энэхүү Конвенцийн оролцогч бөгөөд хилийн нөлөөлөлд өртсөн бол эргийн Талууд хэрвээ тэд зөвшөөрвөл энэхүү далайн захын оронд ижил төрлийн хилийн усны олон талт хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагаанд оролцох санал тавьж болно.

4.Энэхүү Конвенцийн дагуу байгуулагдсан далайн захын орнуудын далай хамгаалах хамтын байгууллагууд нь хилийн нөлөөлөлд шууд бус өртөж байгаа бол тэдгээрийн ажлыг уялдуулах, хилийн нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах зорилгоор хамтран ажиллах;

5.Хэрвээ нэг ус хуримтлалын талбайд хоёр буюу түүнээс дээш хамтын байгууллага байгаа бол энэхүү усан сангийн хүрээнд хилийн нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах зорилгоор хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулах;

Зүйл 10 ЗӨВЛӨЛГӨӨ АВАХ

Эргийн Талуудын хоорондох зөвлөлгөө авах үйл ажиллагаа нь харилцан бие биеэ хүндэтгэсэн, сайн дурын үндсэн дээр, сайн хөршийн харилцаан дээр аль нэг талын хүсэлтийн дагуу хийгдэнэ.

Ийм зөвлөлгөө авах үйл ажиллагааны үндсэн зорилго нь энэхүү Конвенцийн үндсэн дүрэмд хамаарах асуудлаар хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино. Аливаа зөвлөлгөө нь энэхүү Конвенцийн 9 дүгээр зүйлд заасны дагуу байгуулсан хамтын байгууллага байгаа бол энэхүү байгууллагаар батлуулсан байна.

Зүйл 11 ХАМТАРСАН ХЯНАЛТ-ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ

1.Энэхүү Конвенцийн 9 дүгээр зүйлд заасны дагуу нэгдсэн хамтын ажиллагааны хүрээнд эсвэл Эргийн талуудын тодорхой хэлцлээр хилийн усны байдлын хяналт-шалгалтын хамтарсан хөтөлбөрийг үер, мөсөн хахаа, мөн хилийн нөлөөллийг оролцуулсан хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;

2.Эргийн талууд хилийн усанд тогтмол хяналт, шалгалт хийж байгаа бол тэдгээрийн хаягдал ус болон усан дахь концентраци, бохирдуулагчийн жагсаалт, бохирдлын параметрийг тохиролцоно;

3.Эргийн талууд тодорхой хугацааны давтамжтайгаар хилийн усны байдлын үнэлгээг хоорондоо зохицуулах, хилийн нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр ашгийн талаар хамтран ажиллана; Энэхүү үнэлгээ нь энэхүү Конвенцийн 16 дугаар зүйлд заасан журмын дагуу олон нийтийн сонорт хүргэгдэж байна;

4.Эдгээр зорилгоор эргийн Талууд нь хяналт-шалгалт, хэмжилтийн систем, багаж, тоног төхөөрөмж, шинжилгээний арга, мэдээллийн үнэлгээний журам, бохирдлын хаягдлыг бүртгэх арга зэргийг харилцан тохиролцож, хэрэгжүүлнэ;

Зүйл 12 **ХАМТЫН СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТ**

Энэхүү Конвенцийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг хамтын ажиллагааны хүрээнд Эргийн талууд тодорхой хэлцлийн хүрээнд Эргийн талууд тодорхойлж, батлахаар шийдвэрлэсэн усны зорилтот үзүүлэлт, чанарын шалгуурыг хадгалалтыг хангах зорилгоор энэ талын сонирхолд хүрэхийн тулд тодорхой судалгаа, боловсруулалтыг явуулна;

Зүйл 13 **ЭРГИЙН ТАЛУУДЫН ХООРОНДОХ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО**

1. Энэхүү Конвенцийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Эргийн талууд нь тодорхой хэлэлцээ бусад хэлцлийн дагуу бодит, хүртээмжтэй мэдээллийг солилцоно. Үүнд:

а) хилийн усны экологийн байдлын тухай;

б) одоо байгаа хамгийн сайн технологийн хэрэглээ, ашиглалт, судалгааны үр дүн, түүний боловруулалт энэхүү салбарт хуримтлагдсан туршлага;

с) хаягдал ус, мониторингийн үр дүн;

д) хилийн нөлөөллөөс сэргийлэх, хязгаарлах, багасгах талаар авч хэрэгжүүлж байгаа болон төлөвлөж буй арга хэмжээнүүд;

е) эрх бүхий холбогдох байгууллагуудаас өгч буй хаягдал усны зөвшөөрөлтэй холбоотой зөвшөөрөл, дүрэм, журам;

2. Эргийн талууд хаягдал усны зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөвшилцөхийн тулд өөрсдийн үндэсний дүрэм, журамын талаар мэдээлэл солилцоно;

3. Хэрэв Эргийн аль нэг тал эргийн аль нэг нөгөө талд байхгүй мэдээллийг өгөх санал тавивал хүсэлтийг хүлээн авсан тал энэхүү мэдээллийг хангах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах бөгөөд хүсэлт гаргасан тал энэхүү мэдээллийг бүрдүүлэхтэй холбоотой шаардлагатай бол тэдгээрийн боловсруулалттай холбоотой тодорхой төлбөрийг гаргаж болно;

4. Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Эргийн талууд одоо байгаа хамгийн сайн технологийн худалдааны солилцоо, үйлдвэрийн салбарт шууд хамтын ажиллагаа, түүний дотор хамтарсан үйлдвэр байгуулах, мэдээлэл болон туршлага солилцоо, техникийн тусламж гэх мэт. Мөн эргийн талууд боловсон хүчин бэлтгэх хамтын хөтөлбөр, холбогдох семинар, зөвлөлгөөнийг зохион байгуулна;

Зүйл 14 **МЭДЭЭЛЭЛ, ДОХИОЛЛЫН СИСТЕМҮҮД**

Хилийн нөлөөлөл үзүүлж болохуйц аливаа эрсдэлтэй нөхцөлд талууд бие биедээ шуурхай, цаг алдалгүй мэдээлнэ. Эргийн талууд нь шаардлагатай үед мэдээллийг дамжуулах хүлээн авах зорилгоор мэдээлэл, дохиолол, холбоо барих харилцан зохицуулалтыг хийнэ. Энэхүү систем нь Эргийн талуудын харилцан зохицсоны үндсэн дээр мэдээллийг боловсруулах, дамжуулах, техник-тоног төхөөрөмж, хамтарсан дүрэм, журамын үндсэн дээр хийгдэнэ. Эргийн талууд нь энэхүү зорилгоор тохоон томилогдсон эрх бүхий байгууллага, төвүүдтэй холбоо барих талаар бие биедээ мэдээлнэ.

Зүйл 15 **ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА**

1.Онцгой байдал үүссэн тохиолдолд Эргийн талууд энэхүү зүйлийн 2 дугаарт заасны дагуу тогтсон журмын дагуу аль нэг талын хүсэлтийг үндэслэн харилцан бие биедээ туслана.

2.Эргийн талууд харилцаан бие биедээ туслахтай холбоотой дараахи асуудлаар харилцан тохиролцож, журам боловсруулна.

а)тусламжтай холбоотой удирдлага, хяналт-шалгалт, зохицуулалт, хяналт;

б)Тусламж үзүүлэхтэй холбоотой хүсэлт тавьсан талын дагуу орон нутгийн хөрөнгө гаргах, туслалцаа үзүүлэх, шаардлагатай үед хил нэвтрэх үйл ажиллагааг хялбарчлах;

е)Хохирлыг арилгах, тусламж үзүүлж буй талын иргээдэд учирсан алдагдлыг нөхөн сэргээх, шаардлагатай тохиолдолд 3 дагч этгээдийн нутаг дэвсгэрт гарах боломжийг хангах;

д)тусламж үзүүлэхтэй холбоотой үйлчилгээний зардлыг нөхөх нөхцлийг тохирох;

Бүлэг 16

ОЛОН НИЙТИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

1.Эргийн талууд олон нийтийг хилийн усны байдал, хилийн усны нөлөөллийг зайлуулах, хязгаарлах, багасгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээллээр хангана. Олон нийтийг мэдээллээр хангах энэхүү зорилгын хүрээнд:

а)усны чанарын зорилтот үзүүлэлтийн талаар;

б)өгч буй зөвшөөрлүүдийг ягштал дагаж биелүүлэх нөхцлийн талаар;

с)хяналт-шалгалт үнэлгээний талаар урсгал уснаас авсан дээжийн үр дүнгийн талаар, усны чанарын зорилтот үзүүлэлтийг хангаж байгаа талаар, өгөгдсөн зөвшөөрлүүдэд байгаа нөхцлийн талаар;

2.Эргийн талууд ухаалаг үед олон нийтийг энэхүү мэдээллээр үнэ төлбөргүй хангах олон нийтийн төлөөлөлд хяналт тавих боломжийг хангах, Эргийн талууд мэдээллийн хуулбарыг боломжит үнээр өгөх;

БҮЛЭГ III

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ХААЛТЫН ЖУРАМ

Зүйл 17

ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛГӨӨН

1.Талуудын анхдугаар зөвлөлгөөнийг энэхүү Конвенци батлагдснаас хойш 1 жил илүүгүй хугацаанд хийнэ. Дараагийн ээлжит хуралдаан нь 3 жилд 1 удаа түүнээс цөөнгүй байхаар тогтсон журмын дагуу зохион байгуулна. Ээлжит бус хуралдааныг ээлжит хуралдаанаар энэ талаар шийдвэрлэсэн мөн оролцогчийн аль нэг тал нь энэхүү хуралдааны талаар бичгээр мэдэгдэж үүнийг гишүүдийн гуравны нэг нь дэмжсэн бол энэхүү хуралдааны талаар бүх талуудад мэдэгдсэний дараа 6 сарын дотор зохион байгуулна.

2.Талууд зөвлөлгөөн дээр Энэхүү конвенцийн явцын талаар авч хэлэлцэх бөгөөд энэ зорилгоор:

а)Талуудын хилийн усны хамгаалалт, ашиглалтын талаархи бодлого, арга зүйн хандлага, хилийн усны хамгаалалт, ашиглалтыг цаашид сайжруулах тухай;

б)Энэхүү Конвенцийн оролцогч нэг талын болон бусад талуудын хилийн усыг хамгаалах, ашиглах талаар хоёр талын болон олон талын гэрээр хэлэлцээр байгуулах талаар хуримтлуулсан туршлагын талаар мэдээлэл солилцох;

с)шаардлагатай гэж үзвэл ЕЭЗК, бусад олон улсын эрх бүхий байгууллагуудын тодорхой хороодын туслалцаа дэмжлэгийг энэхүү конвенцийг хэрэгжүүлэхийн тулд авах;

д)Анхдугаар чуулганаар өөрсдийн зөвлөлгөөний дүрэм, журамыг хэлэлцэж батлана;

е)Энэхүү конвенцид засвар оруулах тухай асуудлыг авч хэлэлцэнэ;

ф)Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай аливаа арга хэмжээг авч хэлэлцэнэ;

Бүлэг 18 САНАЛЫН ЭРХ

1.Энэхүү конвенцийн энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Тал бүр саналын 1 эрхтэй байна.

2.Эдийн Засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллагууд нь тэдгээрийн бүрэн эрхийн асуудлаар энэхүү Конвенцийн гишүүн орнуудын тоогоор саналын эрхтэй байна. Эдгээр Байгууллагууд нь гишүүн орнууд нь өөрийн саналаа өгөх эсэхээс хамаарч саналын тоог алдаж болно.

Зүйл 19 НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗАР

Ёвропын Эдийн засгийн комиссын гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь дараахи нарийн бичгийн дарга нарын үүргийг гүйцэтгэнэ.

а)талуудын зөвлөлгөөний бэлтгэлийг хангаж зохион байгуулна;

б)Энэхүү конвенцийн дүрмийн дагуу хүлээн авсан илтгэл, бусад мэдээллийг талуудад хүргүүлнэ;

с)Талуудын тодорхойлсон бусад үүргийг хэрэгжүүлнэ;

Зүйл 20 ХАВСРАЛТ

Хавсралтууд нь энэхүү конвенцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

Зүйл 21 КОНВЕНЦИД ЗАСВАР ОРУУЛАХ

1.Аливаа Тал энэхүү Конвенцид засвар оруулах санал гаргаж болно;

2.Энэхүү конвенцид засвар оруулах асуудлыг Талуудын зөвлөлгөөнөөр авч хэлэлцэнэ;

3.Энэхүү Конвенцид засвар оруулах дурын снал нь ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр ирүүлэх бөгөөд энэхүү асуудлыг хэлэлцэх зөвлөлгөөн эхлэхээс 90 хоногийн өмнө бүх гишүүдийн сонорт хүргэгдсэн байна;

4.Энэхүү конвенцийн өөрчлөлт нь энэхүү Конвенцийн талуудын төлөөллийн консенсуусаар хэлэлцэгдэх бөгөөд талуудын гуравны хоёр нь энэхүү өөрчлөлтийг хүлээн авсан хадгалсан өдрөөс эхлэн 90 хоногийн дараа энэхүү өөрчлөлт хүчин төгөлдөр болно;

Зүйл 22 МАРГААНЫГ ЗОХИЦУУЛАХ

1.Хоёр болон түүнээс олон талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд энэхүү Конвенцийн тайлбар болон түүнийг хэрэглэхтэй холбогдуулан маргаанд оролцогч талуудын хооронд гэрээ байгуулах бусад ямар ч аргаар зохицуулах арга хэмжээг авна;

2.Энэхүү конвенцид гарын үсэг зурах, батлах, хүлээн авахад мөн түүнд нэгдэхэд альч үед аль ч тал энэхүү зүйлийн нэгдүгээр хэсэгт зохицуулагдаагүй Депозитарийг бичгээр өргөдөл гаргаж болох бөгөөд аль нэг тал нь эсвэл хоёулаа дараахи үүрэгтэй болно. Үүнд:

а)маргааныг олон улсын шүүхэд шилжүүлэх;

б)хавсралт 4-д заасны дагуу арбитрийн шилжүүлэх;

3.Хэрвээ маргаанд оролцогч хоёр тал хоёулаа өөрөөр тохиролцолгүйгээр энэхүү зүйлийн 2 дугаар хэсэгт заасан хоёуланг нь сонгосон бол маргаан зөвхөн Олон улсын шүүхэд шилжинэ.

Зүйл 23 ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ

Энэхүү конвенци нь Хельсинк хотноо 1992 оны 3 сарын 17-18-ны өдрүүдэд гарын үсэг зурахад нээлттэй бөгөөд цаашид НҮБ-ын Төв байгууллагуудад Нью-Йорк хотноо 1992 оны 9 сарын 18 хүртэл Европын Эдийн Засгийн комиссын орнууд тэрчлэн Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1947 оны 3 сарын 28-ны 36 дугаар тогтоолын 8 дугаар хэсгийн дагуу ЕЭЗК-ийн зөвлөлдөх эрх бүхий орнууд тэрчлэн ЕЭЗК-ийн гишүүн бие даасан орнуудын байгуулсан эдийн засгийн интеграцийн бүс нутгийн байгууллагууд ба эдгээр гишүүн орнуудад энэхүү конвенциэр зохицуулагдаж байгаа асуудлууд мөн тухайн асуудлаар гэрээ байгуулах бүрэн эрх нь олгогдсон болно.

Зүйл 24

Энэхүү Конвенцийн Депозитариар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга үг хэлнэ.

Зүйл 25 БАТЛАЛТ, ХҮЛЭЭН АВАХ, БАТЛАХ, НЭГДЭХ

1.Энэхүү Конвенци нь Эдийн засгийн интеграцийн бүс нутгийн байгууллагууд, тэдгээрийн улсууд батлалт, хүлээн авах, батлах гарын үсэг зурах эрхтэй.

2.Энэхүү Конвенцид 23 дугаар зүйлд заасан улс орнууд, байгууллагууд нэгдэх эрх нь нээлттэй.

3. 23 дугаар зүйлд заасан аливаа байгууллагууд түүний дотор энэхүү Конвенцийн оролцогч тал энэхүү конвенцид заасан эрх үүргээр бүрэн холбогдсон болно. Хэрэв 1 буюу хэд хэдэн орнууд энэхүү Конвенцийн оролцогч бол мөн энэхүү Конвенцийн байгууллагын гишүүд бол тухайн байгууллага, тухайн орон энэхүү Конвенцид заасан өөрийн үүргээ биелүүлэхийн тулд холбогдох шийдвэрийг авч болно. Энэ тохиолдолд тухайн байгууллага, тухайн гишүүн орон энэхүү Конвенцид заасан эрхийг шууд эдлэж үл болно.

4.23 дугаар зүйлд заасан эдийн засгийн интеграцийн бүс нутгийн байгууллагууд нь өөрийн бичиг баримтад энэхүү конвенциэр зохицуулагдаж байгаа асуудлуудын талаар өөрийн бүрэн эрхийг мэдээлэх ба мөн өөрийн бүрэн эрхийн хүрээндэх томоохон өөрчлөлтийн талаар Депозитари мэдээлэл гаргана.

Зүйл 26 ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

1.Энэхүү Конвенци нь батлалт, хүлээн авах, батлах, нэгдэхтэй холбоотой 16 дугаар баримт бичиг хадгаламжид өгсөнөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан эдийн засгийн интеграцийн бүс нутгийн байгууллагуудад хадгаламжид өгсөн аливаа баримт бичиг нь ийм байгууллагуудын гишүүн орнуудын хадгаламжид өгсөн материалуудад нэмэлт материал болохгүй.

3.23 дугаар зүйлд заасан энэхүү Конвенцийн батлалт, хүлээн авалт, батлах, нэгдэх үйл ажиллагаанд оролцсон аливаа орон, байгууллагууд батлалт, хүлээн авалт, батлах, нэгдэхтэй холбоотой баримт бичгээ хадгаламжид өгснөөс хойш 90 хоногийн дараа энэхүү Конвенцийн батлалт, хүлээн авалт, батлах, нэгдэхтэй холбоотой хэсэг хүчин төгөлдөр болно.

Зүйл 27

ГАРАХ

Аль ч үед энэхүү Конвенци хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дотор аливаа оролцогч тал Депозитарт бичгээр мэдэгдэж Конвенциэс гарч болно. Энэхүү гарах үйл ажиллагаа нь Депозитарт бичгээр мэдэгдснээс 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Зүйл 28

БИЧИГ БАРИМТЫН ЭХ ХУВЬ

Энэхүү Конвенцийн эх хувь нь англи, орос, франц хэл дээр байх бөгөөд бүх бичиг баримт нь адил хүчин төгөлдөр байх ба НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагдана.

Дор гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтнууд энэхүү Конвенцийг БАТЛАМЖИЛЖ байна.

Хельсинк хотноо Мянга есөн зуун ерэн хоёр оны гурван сард үйлдэв.

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ I

“ХАМГИЙН САЙН ТЕХНОЛОГИ” НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1.“Одоо байгаа хамгийн сайн технологи” гэж хаягдал ус, үйлдвэрийн хаягдлыг аль болох хязгаарласан практик ажиллагаанд хэрэглэж болохуйц, боловсруулах процесс, тоног төхөөрөмж, ашиглалтын аргыг хэлнэ. Үүнийг тодорхойлохын тулд аливаа боловсруулах процесс, тоног төхөөрөмж, ашиглалтын арга нь бүхэлдээ буюу аль нэг байдлаар дараахи нөхцлийг онцгой харгалзсан байна.

а)харьцуулах боловсруулалт, тоног төхөөрөмж, ашиглалтын арга нь сүүлийн жилүүдэд туршигдсан байх;

б)шинжлэх ухааны танин мэдэхүй, асуудлын ойлголтод өөрчлөлт, техникийн дэвшлийг дагуулсан байх;

с)энэхүү технологийг эдийн засгийн хувьд хэрэглэх боломжтой байх;

д)тоног төхөөрөмжийг түр зуур суурилуулахдаа шинээр буюу байгаа үйлдвэрийн бааз дээр байх;

е) хаягдал ус болон хаягдлын шинж чанар, хэмжээ;

ф)бага хаягдалтай буюу хаягдалгүй технологи;

2.ингэхлээр “хамгийн сайн одоо байгаа технологи” гэдэг нь цаг хугацааны хувьд техникийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлээр мөн шинжлэх ухааны танин мэдэхүй, асуудлын ойлголтоор өөрчлөгдөж байдаг ойлголт болно.

ХАВСРАЛТ II

ЭКОЛОГИЙН ПРАКТИКИЙН ХУВЬД ХАМГИЙН САЙН БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХЭД ХӨТЛӨХ ЗАРЧМУУД

а)Тодорхой нөхцөлд Экологийн практикийн хувьд хамгийн сайн боломжит арга хэмжээг ач холбогдлын эрэмбээр дараахи нөхцлүүдийг харгалзан үзэх;

Нийгэм болон хэрэглэгчдийн дунд экологийн хор хохиролтой холбоотой тодорхой үйл ажиллагаа, бүтээгдэхүүн тэдгээрийн ашиглалт, эцсийн хаягдалын зайлуултын талаар боловсрол, мэдээллийг түгээх;

б)бүтээгдэхүүний амьдралын үргэлжлэх хугацааны бүх аспектыг хамарсан экологийн практикт хамаатай хууль боловсруулах, хэрэгжүүлэх;

с)хүрээлэн буй орчинд аюултай бүтээгдэхүүн түүний ашиглалт, эцсийн хаягдлын зайлуулалттай холбоотой бараа бүтээгдэхүүний ангилалын талаар ашиглагчдад мэдээлэл өгөх;

д)нийгэмд хүртээмжтэй цуглуулалт, зайлуулах үйл ажиллагааг явуулах;

е)дахин эргэлт, дахин ашиглалт, дахин хэрэглээг бий болгох;

ф)бүтээгдэхүүн, бүлэг бүтээгдэхүүн түүний үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн хөшүүргийг хэрэглэх;

г)хязгаарлалт, хориглолт бүхий лицензи олголтын системийг ашиглах;

2.экологийн практикийн хувьд ямар хосолмол арга бүхэлдээ буюу хэсэгчлэн үр ашигтай болохыг тодорхойлохын тулд:

а)Хүрээлэн буй орчинд аюултай;

i)бүтээгдэхүүн;

ii)бүтээгдэхүүн үйлдвэрлэл;

iii)бүтээгдэхүүн хэрэглээ;

iv) эцсийн бүтээгдэхүүний зайлуулалт;

б)арай бага бохирдуулагч процесс, бүтээгдэхүүнээр орлох боломж;

с)хэрэглээний хүрээ;

д)орлуулах материал, үйл ажиллагааны экологийн боломжит давуу тал ба сул талууд;

е)шинжлэх ухааны танин мэдэхүй, асуудлын ойлголтод гарч буй дэвшил, өөрчлөлт;

ф)хэрэгжүүлэх түр зуурын хүрээ;

г)нийгэм, эдийн засгийн үр дагавар;

3.Ингэхлээр экологийн хувьд хамгийн сайн практик гэдэг нь тодорхой эх үүсвэрт техникийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлээр тэрчлэн шинжлэх ухааны мэдлэг асуудлыг ойлгох хүрээнд цаг хугацааны хувьд өөрчлөлт оруулахыг хэлнэ.

ХАВСРАЛТ III

УСНЫ ЧАНАРЫН ЗОРИЛТОТ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ШАЛГУУРУУДЫГ БОЛОВСРУУЛАХАД МӨРДӨХ ХӨТЛӨХ ЗАРЧМУУД

Усны чанарын зорилтот үзүүлэлтүүд болон шалгуурууд:

а)шаардлагатай гэж үзвэл одоо байгаа усны чанарыг сайжруулах, энэхүү зорилтыг дэмжихийг харгалзах;

б)бохирдлын дундаж ачааллыг багасгахад (ялангуяа хэт аюултай бодисын) тодорхой хугацаанд тодорхой төвшин хүртэл чиглэгдсэн байх;

с)усны чанарын хувьд тодорхой шаардлагыг харгалзах(ундны түүхий ус, усалгааны гэх мэт);

д)хэт мэдрэмтгий, хатуу хамгаалалтын дэглэмтэй усны объектууд, тэдгээрийн хүрээлэн буй орчин, жишээлвэл нуур, газрын доорхи усны нөөц гэх мэтэд тодорхой шаардлагуудыг харгалзан үзэх;

е)усны чанарыг сайжруулахыг дэмжихтэй холбоотой дүрэм, дунд болон удаан хугацааны төлөвлөлт, тэдгээрийн шалгах үзүүлэлт болгон химийн индекс, экологийн ангиллын аргын үндсэн дээр тогтоох;

ф)зорилтот үзүүлэлтийн хүрсэн төвшинг тооцох, тэрчлэн зарим тохиолдолд хаягдал усан дахь бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээн дээр суурилах;

ХАВСРАЛТ IV АРБИТРИЙН ШҮҮХ

1. Энэхүү конвенцийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Тал болон Талууд аливаа нэг маргааныг Арбитрийн шүүхэд өгсөн тохиолдолд Нарийн бичгийн дарга нарын газар Арбитрийн шүүхийн шүүн хэлэлцэх асуудлын талаар түүний дотор зүйл, заалтын аль хэсэгтэй холбоотой маргаан үүссэн талаар мэдээлнэ. Нарийн бичгийн дарга нарын газар энэхүү Конвенцийн бүх талуудад хүлээн авсан мэдээллийг дамжуулна.

2. Арбитрийн шүүх 3 хүнээс бүрдэнэ. Маргаанд оролцогч нэхэмжлэгч болон нэхэмжлүүлэгч талууд тус бүр нэг арбитрийг томилох бөгөөд гуравдагч арбитрийг маргалдагч хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр томилох ба энэ нь арбитрийн даргын үүрэг гүйцэтгэнэ. Гуравдагч арбитр нь маргаанд оролцогч талуудын альч орных биш байх бөгөөд мөн тэдгээрийн нутаг дэвсгэрт оршин суугч биш байхаас гадна тэдгээрт алба хашидаггүй, ямар нэг байдлаар энэхүү маргаанд холбоогүй этгээд байна.

3. Хэрвээ хоёрдугаар арбитр томилогдсоны дараа 2 сарын туршид арбитрийн шүүхийн дарга томилогдоогүй бол маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр ЕЭЗК-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга түүнийг дараагийн 2 сарын хугацаанд томилно.

4. Хэрвээ маргалдагч аль нэг тал нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 2 сарын хугацаанд арбитрийг томилоогүй бол энэ талаар нөгөө тал Европын Эдийн засгийн комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад мэдэгдэх эрхтэй бөгөөд тэрээр дараагийн 2 сарын хугацаанд Арбитрийн шүүхийн даргыг томилно. Арбитрийн шүүхийн дарга томилолт авсны дараа арбитр томилоогүй талд дараагийн 2 сард арбитр томилох хүсэлт гаргана. Хэрэв энэ 2 сарын хугацаанд арбитрийг томилоогүй бол энэ талаар Арбитрийн шүүхийн дарга ЕЭЗК-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд тэрээр дараагийн 2 сард энэхүү арбитрийг томилно.

5. Арбитрийн шүүх нь өөрийн шийдвэрийг олон улсын эрх зүй, энэхүү Конвенцийн дүрмийн дагуу гаргана.

6. Аливаа Арбитрийн шүүх нь энэхүү хавсралтын дүрмийн дагуу өөрийн дүрэм, журмыг боловсруулна.

7. Арбитрийн шүүх нь процедурын асуудлаар, асуудлын мөн чанарыг шийдвэрлэхдээ олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8. Шүүх баримт нотолгоог тогтоохын тулд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

9. Маргалдагч талууд Арбитрийн шүүхийн үйл ажиллагаанд өөрт байгаа бүх хэрэгслийг ашиглан тусламж, дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

а) түүнд холбогдох бүх бичиг баримт, нөхцөл, мэдээллийг гаргаж өгнө.

б) шаардлагатай бол түүнд гэрч, экспертүүдийг байлцуулан тэдгээрийн мэдээллийг сонсох боломжоор хангах

10. Талууд болон Арбитрийн шүүхийн талууд арбитрийн шүүхийн маргаан шийдвэрлэх явцад нууц хэлбэрээр хүлээн авсан мэдээллийн нууцийг хадгална.

11. Арбитрийн шүүх нь аль нэг талын хүсэлтээр түр хугацааны хамгаалалт авч болно.

12. Хэрэв маргаанд оролцогч аль нэг тал нь ирэхгүй байгаа буюу арбитрийн шүүхийн ажиллагаанд оролцохгүй байгаа бол нөгөө тал шүүхийн ажиллагааг үргэлжлүүлэн шүүх эцсийн шийдвэр гаргахыг шаардах эрхтэй. Аль нэг тал нь байхгүй байгаа нь шүүн таслах үйл ажиллагаанд оролцохгүй байгаа нь шүүн таслах үйл ажиллагаанд саад болохгүй.

13.Арбитрийн шүүх маргаан шийдвэрлэх явцдаа сөрөг гомдлыг хүлээн авч, сонсч болно.

14.Хэрвээ Арбитрийн шүүх өөрөөр шийдвэр гаргаагүй бол ажил хэргийн тодорхой нөхцөл байдлаас үндэслэн шүүхийн нэхэмжлэлийг арбитрийн гишүүдийн үйлчилгээний зардлыг оролцуулан гаргах ба маргалдагч талууд энэхүү зардлыг тэгш хувааж гаргана. Шүүх энэхүү зардлын талаар данс хөтлөж зардлын эцсийн тайланг талуудад гаргаж өгнө.

15.Энэхүү Конвенцийн аль нэг тал эрх зүйн маргааны чанартай асуудлыг тухайн асуудлаар шүүхтэй тохиролцсоны үндсэн дээр шүүхийн үйл ажиллагаанд оролцож болно.

16.Арбитрийн шүүх нь өөрийн шийдвэрийг байгуулагдснаасаа хойш 5 сарын хугацаанд гаргах бөгөөд хэрвээ шүүх сунгах шаардлагагүй гэж үзвэл 5 сараас үл хэтрэнэ.

17.Арбитрийн шүүхийн шийдвэр нь нөхцөл, шалтгааны тайлбартайгаар гарна. Арбитрийн шүүх өөрийн эцсийн шийдвэрийг Талууд болон Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ. Нарийн бичгийн дарга нарын газар хүлээн авсан мэдээллийг Энэхүү Конвенцийн талуудад илгээнэ.

18.Шүүхийн шийдвэрийг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа нэг талуудын маргааныг аль ч тал энэхүү шийдвэрийг гаргасан Арбитрийн шүүхэд өгч болох бөгөөд боломжтой бол энэхүү дүрмийн дагуу анхны Арбитрийн шүүхийн журмаар шинээр байгуулагдсан шүүхэд дахин хандаж болно.

Конвенцийг орос хэлнээс хөрвүүлсэн

**Я.Цэдэнбалжир
Ц.Бадрах**